

## ТАНИЛЦУУЛГА

*Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа,  
өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн  
хорооны дүрэм батлах тухай*

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45.1.11-д “...төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах” чиг үүргийг Хуульчдын холбоо хэрэгжүүлэхээр заасан.

Хуульчдын холбоо нь хуульд заасан чиг үүргээ хороодоор дамжуулан хэрэгжүүлдэг бөгөөд тус холбооны “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо”-оос төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Хуульчдын анхдугаар их хурлын 2013 оны 10 дугаар тогтоолоор “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо”-г Хуульчдын холбооны сайн дурын хороогоор батламжилсан.

Хуульчдын холбооны зөвлөлийн 2013 оны 9, 21 дүгээр тогтоолоор тус холбооны “Сайн дурын хороодын үйл ажиллагаатай холбоотой нийтлэг журам” болон “Бүртгэлийн нэгдсэн журам”-ыг тус тус баталсан бөгөөд эдгээр журмаар сайн дурын хороог байгуулж бүртгүүлэх, түүний удирдлага, бүтэц, зохион байгуулалттай холбоотой харилцааг зохицуулж, үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Сайн дурын хороодын зохион байгуулалттай холбоотой нийтлэг журмын 3.5 дугаар зүйлийн 1-д “Хорооны дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг байна.” гэж заасан бөгөөд Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны сайн дурын хороогоор батламжлагдсанаас хойш хорооныхоо дүрмийг албан ёсоор батлан гаргаагүй байна.

Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчдын холбооны дүрэм болон Хуульчдын холбооны зөвлөлөөс баталсан холбогдох журамд нийцүүлэн “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны дүрэм”-ийн төслийг боловсрууллаа.

---oOo---

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ “ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭНД  
ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ  
ЭРХЭЛСЭН ХОРОО”-НЫ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

Хорооны дүрэм батлах тухай

Монголын Хуульчдын холбооны сайн дурын хорооны зохион байгуулалттай холбоотой нийтлэг журмын 6.4 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг үндэслэн Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны гишүүдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монголын Хуульчдын холбооны “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Тус дүрмийг зохих журмын дагуу Монголын Хуульчдын холбооны Тамгын газарт бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг хорооны тэргүүн С.Баянмөнхөд даалгасугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

С.БАЯНМӨНХ

**ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА,  
ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН  
ХОРООНЫ ДҮРЭМ**

*Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны гишүүдийн хурлын 2018 оны ... дугаар тогтоолын ХАВСРАЛТ*

## **МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ “ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО”-НЫ ДҮРЭМ**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1 дүгээр зүйл.Ерөнхий зүйл**

1.Монголын Хуульчдын холбооны “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо” /цаашид “Хороо” гэх/ нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монголын Хуульчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-ны дүрэмд заасан төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хуульчдын санаачилгаар байгуулагдсан сайн дурын хороо мөн.

2.Хорооны зорилго нь төлбөрийн чадваргүй иргэдийг хууль зүйн болон өмгөөллийн үйлчилгээгээр хангах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах замаар нийгэмд гүйцэтгэх хуульчдын үүрэг, оролцоо, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх, хуульчдын нэр, хүндийг дээшлүүлэхэд оршино.

3.Хорооны оноосон нэр нь Монголын Хуульчдын холбооны “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо” байна.

4.Хороо нь үйл ажиллагаандаа Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль<sup>1</sup>, Монголын Хуульчдын холбооны дүрэм<sup>2</sup>, Монголын Хуульчдын холбооны сайн дурын хороодын зохион байгуулалттай холбоотой нийтлэг журам<sup>3</sup>, энэ дүрэм болон эдгээрт нийцүүлэн баталсан бусад эрх зүйн баримт бичгийг баримтална.

5.Хороо нь “Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Сүхбаатарын талбай-7, Монголын Хуульчдын холбооны байр” хаягт байрлана.

#### **1.2 дугаар зүйл.Хорооны үйл ажиллагааны үндсэн зарчим**

1.Хорооны зохион байгуулалт нь нэгдмэл байж, хууль дээдлэх, тэгш эрх, шударга ёсыг эрхэмлэж, үйл ажиллагаагаа мэргэжлийн, сайн дурын, ил тод, нээлттэй байдлаар явуулах нь үйл ажиллагааны үндсэн зарчим байна.

#### **1.3 дугаар зүйл.Хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл**

1.Хороо нь энэ дүрэмд заасан зорилгодоо хүрэхийн тулд энэ дүрмийн 1.2 дугаар зүйлийн 1-д заасан зарчмыг удирдлага болгон дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна:

1.1.Холбооноос хууль зүйн туслалцаа хүссэн төлбөрийн чадваргүй иргэнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хууль зүйн болон өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх;

<sup>1</sup> Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Хуульчдын анхдугаар их хурлын 2013 оны 3 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан.

<sup>3</sup> Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2013 оны 9 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан.

1.2.төлбөрийн чадваргүй иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор олон нийтийн сургалт, суурь болон хавсарга судалгаа хийх, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах, иргэдэд зориулагдсан жишиг зөвлөмж, гарын авлага хэвлэн гаргах;

1.3.Холбооны үйл ажиллагаанд оролцох;

1.4.холбогдох хууль, дүрэм, журамд харшлахгүй бусад үйл ажиллагааны хэлбэр.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХОРООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ**

### **2.1 дүгээр зүйл.Хорооны гишүүний бүртгэл**

1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь хүчинтэй байгаа хуульч сайн дурын үндсэн дээр хороонд гишүүнээр элсэнэ.

2.Хорооны гишүүний бүртгэлийг “Монголын Хуульчдын холбооны бүртгэлийн нэгдсэн журам”<sup>4</sup>-ын 7 дугаар бүлэгт заасны дагуу явуулна.

### **2.2 дугаар зүйл.Хорооны гишүүний эрх, үүрэг**

1.Хорооны гишүүн дараах эрхтэй:

1.1.хорооны үйл ажиллагаанд адил тэгш эрхтэйгээр оролцох;

1.2.хорооны гишүүдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх, түүнчлэн биечлэн оролцох боломжгүй тохиолдолд цахим болон бичгээр санал хүргүүлэх;

1.3.хорооны үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;

1.4.хорооны үйл ажиллагааны талаар санал, хүсэлтээ илэрхийлэх, хорооны удирдлагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх;

1.5.хорооны удирдлага, хорооны төлөөлөл бүхий бусад ажил, албан тушаалд өөрийн болон бусдын нэрийг дэвшүүлэх, сонгох, сонгогдох, томилогдон ажиллах, эсхүл ажиллахаас өөрийн хүсэлтээр татгалзах;

1.6.өөрийн хүсэлтээр хорооны гишүүнчлэлээс татгалзах;

1.7.холбоо, түүний бусад бүтцийн байгууллагын үйл ажиллагаанд хамрагдах;

1.8.холбогдох хууль, дүрэм, журамд заасан бусад.

2.Хорооны гишүүн дараах үүрэгтэй:

2.1.энэ дүрэм болон хорооны удирдах зөвлөлийн хуралд оролцсон тохиолдолд хурлын дэгд захирагдах;

2.2.хорооны гишүүдийн санал хураалтад идэвхтэй оролцох;

2.3.хорооны удирдлагаас хариуцуулсан ажил, үүргийг цаг тухайд нь гүйцэтгэх;

2.4.хороог төлөөлж холбооны удирдлага, бусад бүтцийн байгууллагад ажиллаж байгаа бол хорооны нэр хүндийг өндөрт өргөж, хариуцлагатай ажиллах;

2.5.өөрт эрх олгогдоогүй асуудлаар хороог төлөөлж олон нийтэд мэдээлэл өгөхгүй байх;

2.6.холбогдох утас, цахим шуудангийн хаяг өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр хороонд мэдэгдэх;

2.7.холбогдох хууль, дүрэм, журамд заасан бусад.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХОРООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **3.1 дүгээр зүйл.Хорооны удирдлага**

1.Хорооны удирдлагыг гишүүдийн хурал, удирдах зөвлөл, тэргүүн хэрэгжүүлнэ.

---

<sup>4</sup> Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2013 оны 21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан

### **3.2 дугаар зүйл.Хорооны гишүүдийн хурал**

- 1.Хорооны эрх барих дээд байгууллага нь хорооны гишүүдийн хурал байна.
- 2.Хорооны гишүүдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
- 3.Хорооны гишүүдийн ээлжит хурлыг удирдах зөвлөлийн шийдвэрээр жилд нэг удаа хуралдуулах бөгөөд хурлыг тухайн жилийн эхний улиралд багтаан зарлан хуралдуулна.
- 4.Хорооны гишүүдийн хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - 4.1.хорооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 4.2.хороог өөрчлөн байгуулах;
  - 4.3.хороог татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
  - 4.4.Холбооны зөвлөлд илгээх хорооны төлөөллийг сонгох, эгүүлэн татах;
  - 4.5.хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан сонсох, зөвлөмж өгөх;
  - 4.6.хорооны тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх;
  - 4.7.холбогдох хууль, дүрэм, журамд заасан бусад.
- 5.Хорооны гишүүдийн хурал нийт гишүүдийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 6.Энэ зүйлийн 4.1-4.4-д заасан асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын, бусад асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тус тус шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана.
- 7.Хорооны гишүүдийн хурлыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд “Монголын Хуульчдын холбооны сайн дурын хороодын зохион байгуулалттай холбоотой нийтлэг журам”-д заасан журмыг баримтална.

### **3.3 дугаар зүйл.Удирдах зөвлөл**

- 1.Хорооны гишүүдийн хурлын чөлөөт цагт хорооны эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байх бөгөөд хорооны үйл ажиллагаа удирдах зөвлөлөөр дамжин хэрэгжинэ.
- 2.Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
  - 2.1.хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
  - 2.2.хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
  - 2.3.хорооны гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах;
  - 2.4.Холбооны зөвлөлөөс бусад бүтцийн байгууллагад хороог төлөөлөн ажиллах гишүүнд нэр дэвшүүлэх;
  - 2.5.хорооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах, хорооны гишүүдийн хуралд танилцуулах;
  - 2.6.хорооны үйл ажиллагааны талаар хорооны гишүүнээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;
  - 2.7.холбогдох хууль, дүрэм, журамд заасан бусад.
- 3.Удирдах зөвлөл арван хоёр хүртэлх гишүүнээс бүрдэнэ.
- 4.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх ба түүнийг нэг удаа улируулан сонгож болно.
- 5.Удирдах зөвлөлийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тохиолдолд тухайн гишүүний оронд нөхөн сонгууль явагдах хүртэл удирдах зөвлөлийн шийдвэрээр хорооны гишүүдээс түр томилж болно.
- 6.Удирдах зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхтэй:
  - 6.1.хурлаар хэлэлцэх асуудлаар санал, бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

- 6.2.хурлаас шийдвэр гаргахад саналын тэгш эрхтэй оролцох;
- 6.3.хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргаж, хорооны тэргүүнд хүргүүлэх;
- 6.4.хурал таслахгүй байх, зарласан цагт ирэх;
- 6.5.хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцож боломжгүй бол хэлэлцэх асуудлаар бичгээр саналаа илэрхийлэх;
- 6.6.хурлын дэгд захирагдах;
- 6.7.удирдах зөвлөлийн бусад гишүүдийн үзэл бодол, саналд хүндэтгэлтэй хандах;
- 6.8.удирдах зөвлөлийн үйл ажиллагааг тасалдуулахгүй авч явах;
- 6.9.холбогдох утас, цахим шуудангийн хаяг нь өөрчлөгдсөн тухай бүрт хорооны нарийн бичгийн даргад мэдэгдэх;
- 6.10.өөрт нь эрх олгогдоогүй асуудлаар хороо, удирдах зөвлөлийг төлөөлж мэдээлэл өгөхгүй байх;
- 6.11.хорооны тэргүүн, удирдах зөвлөлөөс хариуцуулж өгсөн ажил, үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;
- 6.12.удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг биелүүлэх.

7.Удирдах зөвлөлийн тухайн жилийн нийт хурлын гуравны хоёроос дээш хувьд оролцоогүй, эсхүл тухайн гишүүний ирцээс шалтгаалан хурал хоёр ба түүнээс дээш удаа хойшлогдсон тохиолдолд түүнийг эгүүлэн татах асуудлыг хорооны гишүүдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

### **3.4 дүгээр зүйл.Удирдах зөвлөлийн хурал**

- 1.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.
- 2.Хурал ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит хурал сард нэг удаа хуралдана.
- 3.Удирдах зөвлөлийн хурлыг хорооны тэргүүн зарлан хуралдуулах бөгөөд дараах тохиолдолд удирдах зөвлөл заавал хуралдана:
  - 3.1.хорооны тэргүүн эсхүл удирдах зөвлөлийн гурваас доошгүй гишүүд хурал хийх санаачилга гаргасан;
  - 3.2.хорооны гишүүдийн 25-аас дээш хувь хурал хийхийг шаардсан.
- 4.Энэ зүйлийн 3-д заасан тохиолдолд хорооны тэргүүн ажлын 10 өдөрт багтаан удирдах зөвлөлийг хуралдуулна.
- 5.Хурлыг удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэйд тооцно.
- 6.Энэ зүйлийн 5-д заасан ирцэд хүрээгүй бол хурлыг хойшлуулж, хойшлогдсон хурлыг ажлын таван өдрийн дотор хуралдуулахаар хурал даргалагч товлох бөгөөд уг хурал хуралдахаас ажлын гурван өдрийн өмнө хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдэгдэнэ.
- 7.Удирдах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана.
- 8.Хурал болохоос таваас доошгүй хоногийн өмнө хурлын товыг удирдах зөвлөлийн гишүүдэд мэдэгдэнэ. Хурлын товд хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон хурал болох газар, өдөр, цагийг тусгасан байна.
- 9.Хурлын товыг биечлэн, эсхүл утас, цахим шуудангаар удирдах зөвлөлийн гишүүдэд мэдэгдэж баримтжуулсан байна.
- 10.Хурлаар хэлэлцэх асуудлыг хорооны тэргүүн тогтоох бөгөөд хэлэлцэх асуудлын жагсаалт, тэдгээрийн танилцуулга болон холбогдох мэдээлэл, баримт бичгийг хурал болохоос гурван хоногийн өмнө удирдах зөвлөлийн гишүүдэд бичгээр эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 11.Хурлын явцад удирдах зөвлөлийн гишүүн хэлэлцэх асуудал оруулах санал гаргасан бол хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар тухайн асуудлыг хурлаар хэлэлцэж болно.

### **3.5 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн хурлын дэг**

1. Удирдах зөвлөлийн хуралд оролцож буй хэн боловч энэ дүрэмд заасан дэг, дараалалд захирагдана.

2. Удирдах зөвлөлийн хурлыг тэргүүн, тэргүүний эзгүйд түүний сонгосон удирдах зөвлөлийн аль нэг гишүүн даргалан явуулна.

3. Энэ дүрмийн 3.4 дүгээр зүйлийн 5-д заасан ирцэд хүрснээр хурлыг нээнэ.

4. Хурал даргалагч хурлыг нээж, тухайн хурлаар хэлэлцэх асуудлыг дарааллаар нь танилцуулж, удирдах зөвлөлийн гишүүдээс хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал байгаа эсэхийг тодруулна. Хэрэв хэлэлцэх асуудалд нэмэлт оруулах санал гарсан бол энэ дүрмийн 3.4 дүгээр зүйлийн 11-д заасны дагуу шийдвэрлэнэ.

5. Хурлын ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, хуралд ирээгүй гишүүнд хурлын товыг мэдэгдсэн байдал, ямар шалтгаанаар ирээгүй болохыг танилцуулна.

6. Хурлаар хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу асуудал бүрээр дор дурдсан дарааллын дагуу хэлэлцэнэ:

- 6.1. хэлэлцэх асуудлын танилцуулга;
- 6.2. асуулт, хариулт;
- 6.3. санал, дүгнэлт.

7. Хэлэлцэх асуудлын танилцуулга болон холбогдох тайлбарыг тухайн асуудлыг оруулсан буюу санал гаргасан этгээд хийнэ.

8. Хуралд оролцогчид асуулт асуух, санал, дүгнэлт гаргахдаа хурал даргалагчаас тогтоосон дарааллыг баримтална.

9. Хэлэлцэх асуудлаар горимын санал гаргасан бол гарсан санал тус бүрээр санал хураалт явуулна.

10. Хурлаар хэлэлцэх асуудлаар хэлэлцүүлэг явуулж, санал хураалт дууссан даруйд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх нэгдсэн дүгнэлтийг хурал даргалагч гишүүдэд дахин танилцуулна.

11. Санал хураалтын дүнг хуралд оролцсон гишүүдээс тооцно.

12. Хурлын ирцэд бүртгэгдсэн боловч санал хураалт явуулах үед байгаагүй гишүүнийг тухайн асуудлаар санал өгөөгүйд тооцно.

13. Хурлын явцад хэлэлцэж байгаа асуудлын талаар эсрэг байр суурь илэрхийлж, хурлыг орхин гарсан гишүүнийг тухайн асуудлаар эсрэг санал өгсөнд тооцно.

14. Гишүүн хурлаар хэлэлцэх асуудлын талаар бичгээр санал ирүүлсэн бол түүнийг хуралд оролцоноор тооцож, өгсөн саналыг нь санал хураалтад оруулж тооцно. Хуралд хүрэлцэн ирээгүй гишүүн хурлаар хэлэлцэх асуудлын зарим хэсэгт нь санал өгөөгүй бол тухайн асуудлаар санал өгөөгүйд тооцно.

15. Гишүүн ашиг сонирхлын зөрчлийн улмаас хэлэлцэж байгаа асуудлаар санал хураалтад оролцохгүй байж болно.

16. Санал хураах ажиллагааг илээр явуулна.

17. Удирдах зөвлөлийн дөрвөөс доошгүй гишүүн санал хураалтыг нууцаар явуулахыг дэмжсэн бол санал хураалт нууцаар явагдана.



18.Гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар нэг саналын эрх эдэлнэ. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

19.Хуралд хүрэлцэн ирсэн гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргана.

20.Хурлаар хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу бүрэн хэлэлцэж, шийдвэрлэсний дараа хурал даргалагч хурлыг хаана.

21.Хурлын нарийн бичгийн даргыг Холбооны Тамгын газраас томилогдсон ажилтан гүйцэтгэх бөгөөд “Монголын Хуульчдын холбооны сайн дурын хороодын зохион байгуулалттай холбоотой нийтлэг журам”-ын 6.22 дугаар зүйлийн 2-т заасан үүргийг хүлээнэ.

22.Хурлын тэмдэглэл, тогтоолыг хурал дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор гаргах бөгөөд тэмдэглэлд хорооны тэргүүн, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна.

23.Хурлын тэмдэглэлд хурлыг хэзээ, хаана хийсэн, хурал эхэлсэн, дууссан цаг, минут, хуралд оролцсон гишүүд болон бусад хүмүүсийн нэр, хурлын ирц, хурлаар хэлэлцсэн асуудлын дараалал, тухайн асуудлаар гишүүдийн асуулт, хариулт, санал, дүгнэлт, санал хураалтын ажиллагаа, гарсан шийдвэрийн талаарх мэдээллийг тусгана.

### **3.11 дүгээр зүйл.Хорооны тэргүүн**

1.Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хорооны тэргүүн удирдан зохион байгуулна.

2.Тэргүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд түүнийг улируулан сонгож болно.

3.Тэргүүн энэ дүрмийн 3.3 дугаар зүйлийн 6-д зааснаас гадна дараах бүрэн эрхтэй:

3.1.хороог төлөөлж, хорооны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;

3.2.удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах, хурал даргалах;

3.3.хорооны үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, тодорхой ажлыг хороо, удирдах зөвлөлийн гишүүнд хуваарилах, хэрэгжилтийг хангуулах;

3.4.холбогдох хууль, дүрэм, журамд заасан бусад.

4.Тэргүүнд удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэх асуудлыг бие даан шийдвэрлэх, хорооны ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОРООНЫ ГИШҮҮД БОЛОН ХУУЛЬЧИДТАЙ ХАРИЛЦАХ**

### **4.1 дүгээр зүйл.Хороо гишүүдтэйгээ харилцах, санал хураалт, санал асуулга явуулах**

1.Хороо нь үйл ажиллагаандаа нийт гишүүдийн оролцоог хангаж, саналыг тусгаж ажиллахыг эрмэлзэнэ.

2.Хороо нь нийт гишүүдтэйгээ харилцаатай байх, гишүүд хорооны үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлж ажиллана.

3.Хороо нь харилцах утас, цахим шуудангийн хаяг, холбооны цахим хуудаст өөрийн булантай байна.

4.Удирдах зөвлөл холбогдох хууль, дүрэм, журамд заасан тодорхой асуудлаар хорооны гишүүд болон хуульчдын дунд санал хураалт эсхүл санал асуулга явуулж болно.

5.Хорооны гишүүдийн дунд явуулах санал хураалтыг Холбооны Тамгын газрын тусламжтайгаар цахим хэлбэрээр явуулна.

6.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонхын саналаар тухайн асуудлыг шийдвэрлэж, санал хураалтыг хүчинтэйд тооцно.

7.Хорооны үйл ажиллагаанд гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, санал бодлыг тусгаж ажиллах зорилгоор хорооны гишүүд, хуульчдын дунд санал асуулга явуулж болно. Хороо нь санал асуулгын үр дүнг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

#### **4.2 дугаар зүйл.Холбооны бусад бүтцийн байгууллагад ажиллаж байгаа төлөөлөлтэйгээ харилцах**

1.Хороо нь Холбооны зөвлөл болон бусад бүтцийн байгууллагад ажиллаж байгаа төлөөлөлтэйгээ байнгын хамтын ажиллагаатай байна.

2.Хороо нь Холбооны зөвлөл болон бусад бүтцийн байгууллагад ажиллаж байгаа төлөөллөө хорооны гишүүдийн болон удирдах зөвлөлийн хуралд оролцуулан мэдээлэл авч, хамтран ажиллана.

3.Холбооны зөвлөл болон бусад бүтцийн байгууллагад ажиллаж байгаа төлөөлөл нь тус тусын үйл ажиллагаа, шийдвэрийн талаар хорооны удирдлагад тогтмол мэдээлж байна.

### **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **5.1 дүгээр зүйл.Хорооны санхүүжилт**

1.Хорооны санхүүжилт нь хувь хүн, байгууллагын хандив, тусламж, энэ дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанаас олсон орлого болон Холбооноос олгосон санхүүжилтээс бүрдэнэ.

2.Хороо нь орлогоо зөвхөн энэ дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

3.Хорооны санхүүгийн тайлан нээлттэй байх ба хорооны удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланг үйл ажиллагааны тайлангийн хамт хагас жил тутамд Холбооны Тамгын газарт гарган өгч, хорооны гишүүдэд тайлагнана.

#### **5.2 дугаар зүйл.Ажлын хэсэг**

1.Хорооны тэргүүн, эсхүл удирдах зөвлөлийн шийдвэрээр тодорхой ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий, байнгын бус, хэд хэдэн гишүүний нэгдэл бүхий ажлын хэсгийг байгуулж, тодорхой ажил хариуцуулж болно.

2.Ажлын хэсгийг хорооны удирдах зөвлөлийн гишүүн ахлан ажиллах бөгөөд түүнд тухайн асуудлаар хороог төлөөлөн мэдээлэл хийх эрх олгогдсон гэж үзнэ.

3.Ажлын хэсэг нь хорооноос хариуцуулж өгсөн ажлыг цаг тухайд биелүүлж, ажлын тайлан, мэдээг хорооны удирдлагад тогтмол мэдээлж байна.

4.Ажлын хэсэг нь хариуцаж авсан ажлаа эрхлэн гүйцэтгэж, үр дүнгийн талаар хорооны удирдах зөвлөлийн хуралд танилцуулснаар татан буугдана.

#### **5.3 дугаар зүйл.Дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

1.Хорооны дүрмийг хорооны гишүүдийн хурлаар хэлэлцэн батална.

2.Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл санаачлах эрхийг хорооны тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүн эдэлнэ.

3.Хорооны гишүүд нь дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай саналаа хорооны тэргүүн, удирдах зөвлөлд уламжилж болно.

4.Удирдах зөвлөл шаардлагатай гэж үзвэл дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар нийт гишүүдийн дунд санал асуулга явуулж болно.

5.Хорооны дүрмийн шинэчилсэн найруулга, дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Холбооны Тамгын газарт бүртгүүлэх бөгөөд ийнхүү бүртгүүлэхэд Монголын Хуульчдын холбооны бүртгэлийн нэгдсэн журмыг баримтална.

---oOo---